



Хэнтий аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

2019 оны 06 сард

ᠬᠡᠨᠲᠢᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ ᠨᠢᠶᠭᠦᠮ, ᠡᠳᠢᠶᠢᠨ
ᠵᠢᠰᠭᠢᠨ ᠪᠠᠶᠢᠳᠠᠯ



БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД




675 бүртгэлтэй ажилгүй иргэд

Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, ажил идэвхитэй эрж байгаа ажилгүйчүүд 2019 оны 6 сард 675 иргэн байна.




Өмнөх оны мөн үе 19.0 %



60.7%

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 158 (19.0%) хүнээр буурч, 675 болсны 410 (60.7%) нь эмэгтэйчүүд байна.



51.1%

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 345 (51.1%) нь 15-35 насны залуучууд эзэлж байна.

МОНГОЛЫН УЛСЫН СТАТИСТИК АГЫН ТӨВ



МОНГОЛЫН УЛМААСНЫ СТАТИСТИК

ГЭМТ ХЭРЭГ



Аймгийн хэмжээнд 2019 оны 6 сарын байдлаар 402 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 129 (32.2%)-аар буурсан байна.



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2019 оны 6 сард 1104.9 сая төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 489.5 сая төгрөг байна.



Гэмт хэргийн улмаас нас барсан 6 иргэн, гэмтсэн 91 иргэн байна.

Нийт гарсан гэмт хэргийн 17.2 хувь нь согтуугаар үйлдэгдсэн байна.



МОНГОЛЫН УНДЭСНИЙ СТАТИСТИК



МӨНГӨ, ЗЭЭЛ



Банкны системийн хэмжээгээр өөрийн кассаар, 40711.2 сая төгрөгийн орлогын, 42683.7 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийсэн байна.

Монголбанк нь арилжааны банкуудад 20952.2 сая төгрөг хүргүүлж, банкуудаас 1408.1 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Зээлийн өрийн үлдэгдэл 187774.9 сая төгрөгт хүрснээс чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 1909.8 сая төгрөгт хүрч нийт зээлийн үлдэгдлийн 1.0 хувийг эзэлж байна.

Банкууд нь хадгаламжийн 30 гаруй төрлийн бүтээгдэхүүнээр иргэдэд үйлчилж 90198.6 сая төгрөгийн хадгаламж хуримтлуулж ажилласан байна.

ХААН, ХАС, КАПИТАЛ, ТӨРИЙН банкууд нь 50 гаруй нэр төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг иргэдэд жилийн 5-30 хувийн хүүтэйгээр олгож, иргэдийн хугацаатай хадгаламжинд жилийн 7.5-16.7 хувь, хугацаагүй хадгаламжинд жилийн 2.4 -7.4 хувийн хүү олгож байна.



ТӨСӨВ, САНХҮҮ



2019 оны 06 дугаар сарын байдлаар төсвийн орлогод нийт 5117.7 сая төгрөг төвлөрөхөөс 6078.2 сая төгрөг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөө 960.6 сая төгрөг буюу 18.8 хувиар биелэсэн байна.



Татварын бус орлогод төвлөрүүлэх ёстой 413.4 сая төгрөгийн орлогын төлөвлөгөөг 67.2 хувиар давуулан биелүүлж, төсөвт татварын бус орлогоор 691.4 сая төгрөг төвлөрсөн байна.

Орон нутгийн төсвийн байгууллага нийт 29874.0 сая төгрөгийн зарлагатай ажилласан нь төлөвлөснөөсөө 8383.9 сая төгрөгөөр бага зарцуулалттай ажилласан байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС



Ерөнхий индекс өмнөх сарынхаас 9.9 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 7.8 хувь, Хувцас, бөс, бараа, гутал 0.8 хувь, Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 0.7 хувь, Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа 0.2 хувь, Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, Тээврийн бүлэг 0.6 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 0.1 хувь, Бусад бараа үйлчилгээний бүлэг 2.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 8.7 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 4.8 хувь, Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 5.9 хувь, Хувцас, бөс, бараа, гуталны бүлэг 4.6 хувь, Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 8.8 хувь, Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 8.4 хувь, Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 8.4 хувь, Тээврийн бүлэг 8.5 хувь, Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 4.1 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 5.8 хувь, Бусад бараа, үйлчилгээний бүлэг 7.8 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны эцсээс 4.8 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг бүлэг 2.4 хувь, Согтууруулах ундаа, тамхи, мансууруулах бодисын бүлэг 2.5 хувь, Хувцас, бөс, бараа, гуталны бүлэг 2.2 хувь, Орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлэг 2.5 хувь, Гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлэг 2.9 хувь, Эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлэг 5.3 хувь, Тээврийн бүлэг 0.3 хувь, Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээний бүлэг 1.4 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлэг 2.2 хувь Бусад бараа, үйлчилгээний бүлэг 4.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



©AsiaWebDirect



Орлог бүхий үйлдвэрлэл / Үйлдвэрлэл / Үйлдвэрлэл / Үйлдвэрлэл / Үйлдвэрлэл

АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны 6 сард 11928,4 сая төгрөг буюу 44.2 хувиар өслөө.



Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны 6 сард 2986.1 сая төгрөг буюу 98.2 хувиар өслөө.



МОНГОЛ
ТӨРИЙН
СТАТИСТИК
ТӨВ
ОЮУН



Анхаарал тавьсанд баярлалаа

Веб хуудас: <http://khentii.nso.mn>

И-мэйл: khentii@nso.mn

statistickhentii@yahoo.com

Фейсбүүк хуудас: [Khentii statistic](#)

Холбоо барих:70562303

70562348

НЭВТРЭХ | АШИГЛАХ ЗААВАР | ХОЛБОО БАРИХ | EN



СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

СТАТИСТИК

ФАЙЛЫН САН

ДЭД МЭДЭЭЛЛИЙН САН

АРГАЧЛАЛ, АРГА ЗҮЙ

МЭДЛЭГЭЭ ШАЛГАЯ

СОНИРХОЛТОЙ СТАТИСТИК

www.khentii.nso.mn